



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 21 өдөр

Дугаар А/18

Мөрөн сум

Төсөвт өртгийн дээд хязгаар
тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.6, 65 дугаар зүйлийн 65.1.4, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн ээлжит IX хуралдааны 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн орон нутгийн хөгжлийн сан дахь “Зураг төсвийн сан”-аас санхүүжүүлэх шинээр барих, засварлах, шинэчлэх барилга байгууламжийн ажлын зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаарыг хавсралтаар баталсугай.

2. Төсөл арга хэмжээний зураг, төсвийг боловсруулах зөвлөх үйлчилгээ нийлүүлэх гүйцэтгэгч сонгож гэрээ байгуулах, хэрэгжилтийг хангуулах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулахыг аймгийн Орон нутгийн өмчийн газар (Б.Должинсорогдог)-т үүрэг болгосугай.

3. Төсөл арга хэмжээнүүдийн зураг төсвийн үнийг хавсралтад заагдсан эх үүсвэрээс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Базар), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Оюунтуяа)-т тус тус даалгасугай.

4. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Хөвсгөл аймагт хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний зураг, төслийн ажлын даалгавар, техникийн нөхцөл, техникийн тодорхойлолт зэрэг холбогдох баримт бичгийг бэлтгэн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Оюунтуяа), сумын Засаг дарга, агентлаг байгууллагын удирдлагуудад тус тус үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т даалгасугай.

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Аймгийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр
сарын 21-ний өдрийн А/18 дүгээр
захирамжийн хавсралт

АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН ДАХЬ “ЗУРАГ
ТӨСВИЙН САН”-ААС САНХҮҮЖҮҮЛЭХ ШИНЭЭР БАРИХ, ЗАСВАРЛАХ,
ШИНЭЧЛЭХ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ
ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨРИЙН ТӨСӨВТ ӨРТГИЙН ДЭЭД ХЯЗГААР

№	Арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	тайлбар
1	Өрхийн эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилгын /Хөвсгөл, Мөрөн сум, 5, 6, 12 дугаар баг/ ажлын зураг төсөл боловсруулах	20,000,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна
2	Алаг-Эрдэнэ сумын Хатгал тосгоны 15 ортой эрүүл мэндийн төвийн барилгын ажлын зураг төсөл боловсруулах	32,000,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна
3	Ханх сумын “Соёлын төв”-ийн /250 хүний хүчин чадалтай/ барилын ажлын зураг төсөл боловсруулах	35,000,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна
4	Мөрөн сумын “Гурван-Эрдэнэ” ерөнхий боловсролын сургуулийн өргөтгөлийн барилга /320 хүүхдийн хүчин чадалтай, хоолны газар, спорт заалтай/	50,000,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна
5	Аймгийн нийтийн номын сангийн Хүүхдийн уншлагын танхим, вестибюль, гадна фасадны засварын болон сантехникийн ажлын зураг төсөл боловсруулах	10,000,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна

6	Цагааннуур сумын "Соёлын төв"-ийн /250 хүний хүчин чадалтай/ барилын ажлын зураг төсөл боловсруулах	35,000,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна
7	Эрдэнэбулган сумын Засаг даргын Тамгын газрын барилгын их засварын ажлын зураг төсөл боловсруулах	12,000,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна
8	Эрдэнэбулган сумын ЕБС-ийн бага сургуулийн хичээлийн байрны засварын ажлын зураг төсөл боловсруулах	10,000,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна
	Нийт дүн	204,000,000	

___оОо___